



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 35

Алтай

Нэрэмжит болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12 дахь заалт, Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Дарив сумын бүрэн дунд сургуулийг Монгол Улсын Гавьяат эдийн засагч Аюурзанын Базархүү агсны нэрэмжит болгосугай.

2. Монгол Улсын Гавьяат эдийн засагч Аюурзанын Базархүү агсны нэрэмжит Дарив сумын бүрэн дунд сургуулийн хаяг, албан хуудасны загварыг шинэчлэн баталж, нэрэмжит болгосонтой холбоотой А.Базархүү агсны гавьяат ажил үйлсийг залуу хойч үеийнхэнд таниулж, алдаршуулж ажиллахыг аймгийн Засаг даргад даалгасугай.

ДАРГА



Т.ГАНЗОРИГ